

## **АГУУЛГА**

Оршил	3
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	4
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	11
БҮЛЭГ 3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	12
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....	15
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
БҮЛЭГ 7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ .....	20
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	20
БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДУРСГАЛТ ЗҮЙЛС .....	20
БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	23
БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	27
БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ ...	28
БҮЛЭГ 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв.....	29

**Хүснэгтийн жагсаалт**

<i>Хүснэгт 1.Төслийн талбайн солбицол .....</i>	<i>4</i>
<i>Хүснэгт 2.Уурхайн ажиллах горим ба хугацаа .....</i>	<i>6</i>
<i>Хүснэгт 3.Уулын календарчилсан төлөвлөлт .....</i>	<i>7</i>
<i>Хүснэгт 4.Угаах процесст зарцуулагдах усны хэрэглээ .....</i>	<i>9</i>
<i>Хүснэгт 5.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....</i>	<i>17</i>
<i>Хүснэгт 6.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....</i>	<i>19</i>
<i>Хүснэгт 7. Тэр бум модны төлөвлөгөө .....</i>	<i>19</i>
<i>Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментий төлөвлөгөө .....</i>	<i>20</i>
<i>Хүснэгт 9.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....</i>	<i>22</i>
<i>Хүснэгт 10.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....</i>	<i>24</i>
<i>Хүснэгт 11. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирлага зохион байгуулалтын ажлын зардал .....</i>	<i>27</i>
<i>Хүснэгт 12.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь .....</i>	<i>28</i>
<i>Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт .....</i>	<i>29</i>

## Оршил

Ашигт Малтмалын Газраас “Арголд” ХХК-нд олгосон байна. 2016 оны 03-р сарын 04-ний өдөр Төв аймгийн Заамар сумын нутагт орших Бумбат-3 нэртэй 612.67 гектар талбайд ашигт малтмал ашиглах MV-020483 тоот тусгай зөвшөөрлийг “Арголд” ХХК-нд шилжүүлсэн байна. “Юбиксолюшн” ХХК-н тусгай зөвшөөрлийн 99011487107 тоот улсын бүртгэлийн дугаартай “Юбиксолюшн” ХХК- геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч 2021.09.28-ны 374 тоот шийдвэрээр шилжүүлсэн.

2023 онд уг тусгай зөвшөөрлийг кадастрын хэлтсийн даргын 2023.06.15-ний 197 тоот шийдвэрээр тусгай зөвшөөрлийн 9011075082 тоот улсын бүртгэлийн дугаартай “Гурвантамга” ХХК-д шилжүүлсэн.

### **БОМТ боловсруулах аргачлал:**

Тус төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Тус төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.


## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2.2.Төслийн товч тодорхойлолт

“Дэнж-1, Дэнж-2” хэсгийн алтны шороон орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт харьяалагдах бөгөөд MV-020483 дугаар бүхий ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбайд Улаанбаатар хотоос баруун хойш 220 км, Заамар сумын төвөөс 20 км-т, Шижир алт сууринаас 15 км зайд байрлана. Байр зүйн зургийн M-48-126, 138 нэрэлбэрт оршино.

Хүснэгт 1.Төслийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104° 36' 1.02"	48° 19' 41.82"	20	104° 34' 37.08"	48° 18' 41.77"
2	104° 33' 16.46"	48° 19' 41.82"	21	104° 34' 37.11"	48° 18' 38.52"
3	104° 33' 16.51"	48° 19' 38.11"	22	104° 34' 56.53"	48° 18' 38.59"
4	104° 33' 26.22"	48° 19' 38.15"	23	104° 34' 56.55"	48° 18' 35.35"
5	104° 33' 26.29"	48° 19' 30.05"	24	104° 35' 8.68"	48° 18' 35.41"
6	104° 33' 33.57"	48° 19' 30.08"	25	104° 35' 8.71"	48° 18' 32.17"
7	104° 33' 33.63"	48° 19' 23.61"	26	104° 35' 13.56"	48° 18' 32.18"
8	104° 33' 43.34"	48° 19' 23.64"	27	104° 35' 13.6"	48° 18' 27.32"
9	104° 33' 43.43"	48° 19' 13.93"	28	104° 35' 16.03"	48° 18' 27.33"
10	104° 33' 55.57"	48° 19' 13.98"	29	104° 35' 16.05"	48° 18' 24.09"
11	104° 33' 55.07"	48° 19' 1.03"	30	104° 35' 18.49"	48° 18' 24.11"
12	104° 34' 0.53"	48° 19' 1.05"	31	104° 35' 18.46"	48° 18' 25.73"
13	104° 34' 0.55"	48° 18' 57.82"	32	104° 35' 23.32"	48° 18' 25.74"
14	104° 34' 7.83"	48° 18' 57.85"	33	104° 35' 23.36"	48° 18' 19.26"
15	104° 34' 7.91"	48° 18' 48.12"	34	104° 35' 28.21"	48° 18' 19.29"
16	104° 34' 15.19"	48° 18' 48.15"	35	104° 35' 28.29"	48° 18' 10.22"
17	104° 34' 15.22"	48° 18' 44.91"	36	104° 35' 28.77"	48° 18' 10.22"
18	104° 34' 27.36"	48° 18' 44.96"	37	104° 35' 28.84"	48° 18' 1.82"
19	104° 34' 27.39"	48° 18' 41.72"	38	104° 36' 1"	48° 18' 1.82"



Зураг 1.Төслийн байршил

### 2.3.2.1. Ил уурхайн тоног төхөөрөмж

Үржил шимт хөрсийг хуулахдаа хайгуулын шугамын дагуу баруун урдаас зүүн хойд зүгт 0.3 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж, экскаватор-автосамосвалын хослолоор уурхайн баруун талд салхины нөмөр газар тусгайлан сонгосон талбайд тээвэрлэн овоолно. Үржил шимт хөрсний овоолгыг 3-5 м өндрөөр байгуулж, ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг гүйцэтгэх боломжтой байхаар төлөвлөв.

### 2.4. Ил уурхайн ашиглалтын технологи, ажиллах горим

Ордыг ашиглах технологи. Ашиглах талбайн сонголтыг ордын нарийвчилсан хайгуулын нөөцийн хүрээнд цооногуудын үр дүн ба байрлал, уурхайн хүчин чадал, ордыг ашиглах дараалал, нөөцийг бохирдол багатай ашиглах боломж, аюулгүй

ажиллагааны шаардлага, байгаль орчны нөхөн сэргээлтийн хэтийн төлөв байдал, эдийн засгийн хувьд хямд төсөр байх нөхцөл боломжууд зэргийг үндэслэн хийлээ.

## 2.2. Доголын өндөр

Дэнж-1 уурхайн хөрсний зузаан болон элсний зузааны нийлбэр дунджаар 9.2 м тул доголын өндөр 5 м, Дэнж-2 уурхайн хөрсний зузаан болон элсний зузааны нийлбэр дунджаар 38.2 м байна. Тиймээс ажлын доголын өндөр 5 м ажлын бус догол 10 м байхаар төлөвлөв. Доголын аюулгүйн зай 3.5 м, траншейн 10 градус.

## 2.3. Ажлын доголын хажуугийн өнцөг

Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож 60-70 градус байхаар сонгосон.

## 2.4. Ажиллах горим

Уурхай нь 2024 онд 03-р сарын 01-ээс бэлтгэл ажлыг эхлүүлж, 04-р сарын 1-ээс 10-р сарыг дуустал хөрс хуулах, элс олборлох, элс угаах, нөхөн сэргээлт хийх болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагийн уртасгасан хугацаагаар явагдана. Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаан баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ. 2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр Дэнж-2 ордын хойд хэсгийн дээд болон доод блокуудыг олборлоно. Энэ онд 317.9 мян.мз хөрс хуулж, химийн цэврээр 4.42 кг алт бүхий 12.67 мян.мз элс олборлоно.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим ба хугацаа

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанли хоног	хоног	240
2	Баях ёслол	хоног	5
3	Төлөвлөгөөт засвар үйлчилгээ	хоног	5
4	Төлөвлөгөөт бус зогсолт	хоног	4
5	Бэлтгэл ажлын хоног	хоног	30
6	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	цаг	196
7	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	тоо	12
8	Ээлжийн тоо	цаг	2
9	Ээлжин үргэлжлэх хугацаа, цаг	цаг	12
10	Ээлжин дэх сул зогсолт /үдийн цай, тос, түлш нэмэх/	цаг	1,5
11	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	цаг	0,5
12	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	10
13	Цаг ашиглалт	цаг	0,9
14	Жилд ажиллах нийт цаг	цаг	3528

## 2.5. Уурхайн хүчин чадал

2024 оны 3-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж, Дэнж-1, Дэнж-2 уурхайд өмнөх онд ашигласан техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд уулын ажлаар 12.67 мян.м<sup>3</sup> алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

## 2.6. Календарь төлөвлөлт

Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг жилийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаатай уялдуулж 2024 онд 12.67 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулахаар тооцлоо.

Хүснэгт 3. Уулын календарчилсан төлөвлөлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Ажиллах улирал			Нийт уулын ажлын хэмжээ
			2-р улирал	3-р улирал	4-р улирал	
1	Уулын цул	мян.м <sup>3</sup>	440.1	448.3	149.5	1037.9
2	Нийт хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	423.5	423.5	141.2	988.2
3	Эрс олборлолт	мян.м <sup>3</sup>	16.6	24.80	8.30	49.7
4	Хөрс хуулалтын коэффициент	м <sup>3</sup> /м <sup>3</sup>	25.5	17.1	17.0	19.9
5	Угаах элсний хэмжээ	мян.м <sup>3</sup>	16.60	24.80	8.30	49.7
6	Дундаж агуулга	Мг/м <sup>3</sup>	266	269	279	269
7	Металлын хэмжээ /х.ц/	Кг	4.42	6.68	2.27	13.4
8	Металл авалт	%	88.3	88.3	88.3	88.3
9	Металлын хэмжээ /х.ц/	кг	3.9	5.90	2.00	11.8

## 2.7. Хөрс хуулалтын технологи

Уурхайг нээх үед шимт хөрсийг 0.2 м-ийн зузаантайгаар хуулан уурхайн талбайн ойр овоолгыг үүсгэнэ. Экскаватор автосамовалуудын хослолоор хөрс хуулалтын ажлыг гадаад болон дотоод овоолгод байрлуулах ба мөн алт агуулсан элсийг скруббер байрласан талбайд зөөвөрлөхөөс гадна скрубберээр угаагдан гарсан эфель, галийн овоолго хийнэ.

## 2.8. Элс олборлолтын технологи

Элс олборлох ажил нь элсийг уурхайгаас элсний агуулахад ухаж тээвэрлэх, элсний агуулахаас угаах төхөөрөмжийг элсээр хангах гэсэн процессуудаас бүрдэнэ. Олборлолтын доголд элсийг экскаватороор ухаж автосамосвалд ачиж тээвэрлээд угаах талбайд хураах ба баяжуулах процесст оруулна. Элсний давхаргын зузаанаас хамаараад олборлолтын доголын өндөр нь хувьсах бөгөөд элсний давхарга /0.8-2.2м/ хооронд хэлбэлзэнэ.

Алт агуулсан элсний давхаргыг олборлох явцад улны хяналт, дээж авалтын ажлыг сайтар зохион байгуулж, уг үнэт металлын хаягдал бохирдлыг төлөвлөсний дагуу бага байлгах улмаар байгалийн нөөцийг аль болох бүрэн гүйцэд ашиглахыг эрмэлзэнэ. Бохирдол үүсэх гол шалтгаан нь нимгэн давхаргатай алт агуулсан элсний үе

дээр хамгаалалтын цамц буюу ул, тааз, хажуугийн хөрсийг нэмж тооцсоноос үүдэж байна.

### *2.9. Овоолгын ажил*

Дэнж-2 хэсгээс 2024 онд 317.9 мян.м<sup>3</sup> хөрс нь хуулах бөгөөд 2024 онд үүсгэсэн хоосон орон зайд шилжүүлж ашиглалтын ажилтай зэрэгцэн дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийнэ. 2023 оны ашиглалтын жилд 12.67 мян.м<sup>3</sup> элс олборлохоор байна.

### *2.10. Хөрс хуулалт, элс олборлолтын процесс*

Хөрс зузаан Дэнж-2 хэсэг дээр 37.4 м байна. Элсний давхаргын зузаан дунджаар Дэнж-2 дээр 2.2 м тус тус байна. Аж ахуйн нэгжид бэлэн байгаа экскаватор болох 5.2 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай Doosan DX700LC экскаватор хөрс хуулалтанд ажиллана, элс олборлолтод Doosan DX300LC маркийн 1.5 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай экскаватор ажиллана. Элс тээвэрлэлтэнд 20 тн даацтай HOWO-20 загварын автосамосвал, хөрс тээвэрлэлтэнд 60 тн даацтай TL875B загварын авто самосвал ажиллана. Элсний давхаргын зузаан, чулуулгийн шинж чанар, операторын ур чадвараас хамаараад экскаваторын утгуур дүүргэлт 90-98%, нэг автосамосвалд ачилт хийх хугацаа 2-3 мин байна. Элс угаан баяжуулалтын сарууд болох 5-10-р саруудад элс олборлолтын жигд бус ажиллагаа, тээврийн хэрэгслийн саатлаас угаах төхөөрөмжийг сул зогсоохоос сэргийлж угаах төхөөрөмжийн дэргэд 3000 м<sup>3</sup> буюу угаах төхөөрөмжийг доод тал нь 7 хоног тэжээх элсний нөөц бүрдүүлнэ.

### *2.11. Хөрс, элс тээвэрлэх процесс*

18 м<sup>3</sup>-ийн тэвшний багтаамж бүхий HOWO-20 загварын автосамосвал элс тээвэрлэлтэнд, хөрс тээвэрт 30 м<sup>3</sup> тэвшний багтаамжтай TL875B экскаватор ажиллуулах ба тээвэрлэлтийн зай дунджаар хөрсөнд 0.4-0.5 км, элсэнд 4.2 км байх юм.

### *2.12. Хаягдлын сан*

Алт угаалтын явцад үүсэх технологийн хаягдал нь том ширхэгтэй чулуу, хайрганы овоолго /гааль/ ба жижиг ширхэгтэй элсний /эфель/ далан хэлбэртэйгээр үүснэ. Шүүгдсэн усыг цэвэр усны нууранд хуримтлуулна. Хаягдлын усан сангийн эзлэхүүнийг тооцохдоо угаан баяжуулах хэсгийн үйл ажиллагааг тасралтгүй 7 хоног хангаж байхаар төлөвлөв.

Технологийн усан сангийн багтаамж  $V_{\text{тех/усан сан}} = W_{\text{тех/ус}} * 24\text{цаг} = 157.43 * 24 = 3778.32 \text{ м}^3$ , цэвэр усны хоногийн хэрэглээ нь  $472.3 \text{ м}^3$  бөгөөд цэвэр усны сангийн багтаамж нь  $V_{\text{цэвэр ус}} = W_{\text{цэвэр ус}} * 12 = 39.6 * 12 = 472.3 \text{ м}^3$  байна. Нуурын ёроолд тунасан лагийг сардаа 1 удаа цэвэрлэгээ хийнэ. Хаягдлын санд хуримтлагдсан технологийн ус нь тунаах нуураар дамжин цэвэршээд эргээд технологид хэрэглэнэ. Усан сангийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдалд байнга хичнэлт тавьж ажиллана.



Мөн 2023 онд усан сангийн зарим хэсгийн шугам хоолойг сайжруулах ажил хийхээр зардлыг эдийн засгийн хэсэгт төлөвлөв.


### 2.13. Усан хангамж

Хайлаастын баруун салаа Дэнж-1 ба Хайлаастын хөндийн баруун дээд хөндлөн чиглэлээр байрлах Дэнж-2 алттай давхарга нь усан хагалбарын хэсэгт 1190-1220 м-ийн түвшинд буюу Хайлаастын хөндий 180-200 м-ийн харьцангуй өндөр түвшинд байрлах ба хайгуулын цооногуудад уст үе, давхарга тогтоогдоогүй тул ашиглалтын үед карьерын мөргөцгийг хуурайшуулах шаардлагагүй, гидрогеологийн нөхцөлийн хувьд олборлолтын тааламжтай нөхцөлтэй юм.


Технологид шаардлагатай усны хэмжээ. Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 25%-ийг цэвэр усаар сэлбэх ба 75%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м<sup>3</sup> элс угаахад 4 м<sup>3</sup> ус хэрэглэхээр тооцоолов.

#### Хүснэгт 4. Угаах процесст зарцуулагдах усны хэрэглээ

№	Он	Угаан баяжуулах элсний хэмжээ	1м <sup>3</sup> элс угаах усны зарцуулалт	Ус ашиглалтын коэффициент	Технологийн усны хэмжээ	Цэвэр усны хэмжээ
	2024	49.7 мян.м <sup>3</sup>	4.0 м <sup>3</sup>	75%	149,1 мян.м <sup>3</sup>	49,7 мянм <sup>3</sup>



А-А зүсэлт



Зураг 2.Хаягдлын сан дэвсгэр болон зүсэлт

## **БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Тус талбай нь бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладгаараа онцлогтой. Заамарын нуруу нь Туул голын баруун эрэг, талбайн төв хэсгээр орших бөгөөд 1500-1815.5 м /Цагаан уул/ үнэмлэхүй өндөртэй, уулсын хажуу нь олон тооны гол, жалгаар хэрчигдсэн, 25-300-ын налуутай /заримдаа 400/, харьцангуй өндөршилт нь 300-500 м.

Уул нуруудыг зааглаж буй хотгорууд нь сул хэрчигдсэн, 950-1100 м өргөгдсөн гадаргуунууд бөгөөд зүүн хойш чиглэлтэй, 4-7 км өргөнтэй.

**Усан сүлжээний хувьд** хамгийн том гол нь Орхон голын баруун цутгал болох 600 км орчим урттай, 1.0-4.0 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Гольдрол нь тохойрол, тахиралт ихтэй, олон тооны хар ус жижиг аралтай бөгөөд гольдролын өргөн 30-100 м, гүн нь 0.5-2.6 м хүрдэг. Туулын голын баруун гар талын цутгал болох Хайлаастын хөндий нь 9 орчим км урттай, 500-800 м өргөнтэй, олон салаа жалга, хөндий амнуудтай ба тэдгээрийн урт нь 2.0-3.0 км, өргөн нь 400-600 м болно.

**Цаг уурын хувьд** эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн 1-р сард агаарын хэм -370, хамгийн дулаан 7-р сард агаарын хэм +320 хүрдэг. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367.3 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80% зун бороо байдлаар ордог. Өвөл 5-25 мм цасан бүрхүүл тогтож, хөрсний хөлдөлтийн гүн 2-5 м хүрдэг. Голчлон баруун хойноосоо 5-10 м/сек хурдтай салхилах ба зарим тохиолдолд 20 м/сек хүрдэг.

**Хүн амын хувьд** хүн амын суурьшилт нягт биш, голчлон мал аж ахуй болон газар тариалан эрхэлдэг халхчууд амьдардаг ба Заамар сумын хэмжээнд 3000 орчим хүн суурьшдаг. Тус дүүрэг нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй бүс нутаг юм.

**Дэд бүтцийн хувьд** хамгийн ойр орших улсын чанартай авто зам нь Улаанбаатар – Булганы сайжруулсан зам бөгөөд Туулын гүүрнээс орд хүртэл 22 км зайтай байдаг. Суурин газраас Заамар сумын төв, алт олборлох үйлдвэрийн суурин (Шижир алт) байх бөгөөд эдгээр газрууд нь Улаанбаатар - Дархан - Сибирийн эрчим хүчний системтэй холбогдсон байна. Заамарын алтны бүлэг шороон ордыг олборлох явцад орон нутгийн чанартай авто замын сүлжээ сайн хөгжсөн ба авто зам нь ердийн ба зарим хэсэгтээ шороон хучилтаар сайруулсан байна. Борнуур-Баясгалантын 110кВт-ын төвийн төвийн эрчим хүчний шугам, 110/6-ийн Баясгалант өртөөнөөс хуваарилан дамжуулах 6-35 кВт-ын шугам нь 1.2 км зайтай байрласан байдаг.

### **БҮЛЭГ 3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

#### *4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ*

2024 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

#### *4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл*

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

#### *4.2. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл*

2024 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

#### *4.3. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл*

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

#### *4.4. Нөхөн сэргээж буй газрыг хүн мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах*

Уурхайн эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дууссан газрыг бусад хүчин зүйлээс болж буцаж эвдэрч, доройтохоос хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### 1. Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

### 2. Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налууугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

### 3. Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

## **Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж**

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх

- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулах, шимт хөрсийг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэд ашиглах
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах
- Барилга, байгууламж байршуулсан хэсэгт үерийн ус зайлуулах шуудуу татах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана

## **БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

### Уурхайн нөхөн сэргээлт

Техникийн нөхөн сэргээлт. Ордын хувьд ашиглагдсан орон зай буюу уурхайн ухшийг уурхайн олборлолтын эхэн үеэс хоосон орон зай үүсэх үед дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж уулын ажилтай техникийн нөхөн сэргээлтийн ажлыг давхар явуулснаар тодорхой хэмжээний зардлыг хэмнэж байгаа юм. Техникийн нөхөн сэргээлтийг хийх ихэнх зардал нь ашиглалтын зардалд шингэсэн бөгөөд биологийн нөхөн сэргээлт хийхийн өмнө ахин хэвгийжүүлэх дагтаршуулах ажил хийгдэнэ. Энэ онд шинээр эвдрэлд орох 1 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийхээр байгаа бөгөөд зардал нь ашиглалтын зардалд шингэсэн. Мөн дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажил, талбайд тэрбум мод төслийн хүрээнд мод тарихаар тусгав.

## **БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “ГУРВАН ТАМГА” ХХК-ийн “Дэнж-1, Дэнж-2” хэсгийн алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.



**Хүснэгт 5.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Баримтлагдах эрх зүйн баримт бичиг
	Агаарын чанар салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцорын агууламж 300 м зайд 103 мкг/м <sup>3</sup> буюу стандарт утгаас 3 мкг/м <sup>3</sup> хэмжээгээр илүү байна	Уурхайн дотоод тээвэрлэлтийн замыг услах	Тоос босох гадаргуу	Мот/цаг	800,000	
		Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Уурхайн бүх авто машинуудад	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	
		Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	
Нийт 800,000						
	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	Үйл ажиллагааны зардалд орно		Дотоод үйл ажиллагааны зардалд	
		Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана	Үйл ажиллагааны зардалд орно		Дотоод үйл ажиллагааны зардалд	
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Уст цэгт	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орно	Дотоод үйл ажиллагааны зардалд	
		Хаягдал усны шугам сүлжээг тоолууржуулах, хяналт тавих , тогтмол шинжилгээ хийлгэх, MNS 4945:2015	Уст цэгт	Орчны хяналт шинжилгээний		

				ажлын зардалд орно.		
<b>Нийт: 500,000</b>						
Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд орно	Дотоод үйл ажиллагааны зардалд		
	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай, авто зогсоол	-	500,000		
<b>Нийт: 500,000</b>						
Ургамлан нөмрөг, Амьтны аймаг	Олон салаа гаргахгүй байх	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	Үйл ажиллагааны зардалд орсон	Үйл ажиллагааны турш		
	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийн хотхонд байрлуулах	Уурхайн хотхонд		500,000		
	Тусгай зөвшөөрлийн талбай доторх ургамлын бүрхэвч, амьтны аймгийн тархацийн талаарх судалгаа	Тусгай зөвшөөрлийн талбайд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.		
<b>Нийт: 1,800,000</b>						

## БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны эцсийн байдлаар нийт 15.48 га талбайн гадаргуу уурхайн үйл ажиллагаанд өртөж байгаагаас уурхайн эдэлбэрт шинээр 1 га талбай өртөж байна. Энэ онд 1 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх бөгөөд зардал нь ашиглалтын зардалд шингэсэн.

### Хүснэгт 6.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт
1	Техникийн сэргээлт	нөхөн Га	1	(Үйлдвэрлэлийн зардалд шингэсэн )	MNS 5914:2008 MNS 5918:2023 MNS 4919:2000 MNS 4920:2000
2	Биологийн сэргээлт	нөхөн га	1	1 000,000	
3	Шимт хөрс хадгалах, хамгаалах	га	0.5	500, 000	
<b>Нийт</b> зардал, төг				1 500 000	

### Хүснэгт 7. Тэр бум модны төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
1.	2024 онд орон нутгийн тогтоож өгсөн талбайд мод тарихаар төлөвлөв.	ш	200	-	5000000	“Тэр бум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд	
<b>Нийт</b>					5000000		

## БҮЛЭГ 7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

2024 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас тогтоож өгсөн 5.0 га газарт өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөөд байгаа юм. Энэхүү зардалд 4,000,000 сая төгрөг төсөвлөв. /Аймгийн саналыг хавсаргав/

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах талбай

№	Х	Ү	Талбайн хэмжээ /га/	Газрын нэр
1	5368448.877	466845.348	5	Тосон
2	5368680.908	467029.667		
3	5368681.199	467171.289		
4	5368442.46	467129.254		

## БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

## БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДУРСГАЛТ ЗҮЙЛС

“Дэнж-1, Дэнж-2” хэсгийн алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Заамар сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Болзошгүй зардал 500000 төг төсөвлөсөн.

## БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	9
1.	Аянга буух	Аянга, цахилгаантай ширүүн бороотой, хүчтэй салхи шуургатай үед гадаах ажлыг түр зогсоох	Уурхайн эдэлбэр газарт	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Осол эрсдэлийн менежментийн

2.	Гал түймэр	Төслийн талбай болон уурхайн хотхонд байршуулсан гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрдлийг тогтмол шалгах. Бүх машин механизмд галын хор байршуулах. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах тэмдэг, тэмдэглэгээ мэдээлэх самбар зэргийг байршуулах.	Ашиглалтын талбай болон уурхайн хотхон	300000	Дотоод үйл ажиллагааны зардалд	2024 онд	төлөвлөгөө, аваар устгах төлөвлөгөө дагаж ажиллана.
3.	Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой газар руу нүүлгэн шилжүүлэхийг ажлыг зохион байгуулна.	Уурхайн талбайд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	
4.	Автомашин осол	Тээврийн хэрэгслийн жолоочид Замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм болон компанийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч сургалтыг зохион байгуулах.	Уурхайн талбай болон тээврийн зам	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	
<b>Нийт</b>		<b>300 000</b>					
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 300 000</b>							

## БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 10.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	
1	Ахуйн	Хог хаягдлын эх үүсвэр бүрд хог хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын хогийн сав байрлуулах. Ангилсан хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөх	400 000	2024 онд	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл MNS5924:2015
		Хог хаягдлыг кодчилсон жагсаалтын дагуу тухай бүрд нь хөтөлж, бүртгэх.	100 000		
		Нүхэн жорлонг стандартын дагуу хүчитгэсэн доторлогоо хийх	500 000		
2	Аюултай	Хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашиглах, шаардлагатай бол орон нутгийн хэрэгцээнд өгөх	-		
		Хэрэглэсэн шатах тослох материалыг хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах	500 000		
		Одоогоор манай улсад аюултай, хортой хог хаягдал устгах үйлдвэр байхгүй байгаа учир Аюултай хаягдлыг “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	-		
<b>Нийт</b>			<b>1 500 000</b>		

## **БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2024 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, Гадаргын болон гүний усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаа төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.


**Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгж зардал	Нийт зардал	Баримтлах стандарт, арга аргачлал
<b>Агаар орчин</b>						
Агаар дахь тоосонцор PM <sub>2,5</sub> , PM <sub>10</sub> , NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO-ийн агууламж	Уурхайн дотоод зам, Уурхайн каррьер, засварын талбай	6 болон 8 сар	3*2 удаа=6	100,000	100,000*6=600,000	MNS 4585:2016 MNS 6063:2010 MNS 6768:2019 MNS 3113:1981 MNS 5885:2008 Агаарын тухай хууль 2012.05.17 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль 2010.06.24
<b>Усан орчин</b>						
Усны ерөнхий шинжилгээ, бактериологийн шинжилгээ, хүнд металл	Унд ахуйн худаг, Цэврийн болон бохирын нуур	6 болон 8 сар	3*2 удаа=6 Унд ахуйн уснаас усны ерөнхий шинжилгээ болон бактериологийн шинжилгээ- 50,000+100,000=150,000*2=300,000 Цэврийн болон бохирын нуурын уснаас усны ерөнхий шинжилгээ болон хүнд металлын шинжилгээ 50,000*2+60,000*2=260,000	Усны ерөнхий хими шинжилгээ- 50,000 Хими бактериологи шинжилгээ- 100,000 Хүнд металлын шинжилгээ- 60,000	Нийт 560,000 төгрөг	MNS /ISO/ 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 4943:2015 MNS 0900:2018 Усны тухай хууль 2012.05.17
<b>Хөрс</b>						



Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, хүнд металл	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд, хотхон, засварын талбай, шатахуун түгээх газар	6 болон 8 сар	$2 * 5 = 10$ Уурхайн шимт хөрсний овоолго, засварын талбай, уурхайн хотхон, шатахуун түгээх газруудаас хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээ $25,000 * 3 = 75,000$ Засварын талбай, шатахуун түгээх газар, ахуйн бохир усны хаягдлаас хүнд металлын шинжилгээ $75,000 * 3 = 225,000$	Хөрсний хяналт шинжилгээний 5 цэгт жилд 2 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 25000 төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 75.0 мян.төг Инженер геодези хөрсний төв лаборатори	Нийт төгрөг 300,000	MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 : 1987 MNS 2305 : 1995
<b>Нийт 1,460,000 төгрөг</b>						

Хяналт шинжилгээ хийх байршлын зураг



Зураг 3.Хяналт шинжилгээний дээж авах байршлууд

### БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирлага зохион байгуулалтын ажлын зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв Төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2024 он			
			Сар ...	Сар ...	Сар ...	
1		2	3	4	5	6
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд			Уурхайн дарга
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	500 000	8-р сард			Уурхайн дарга
3.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	-	11-р сар			“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд
4.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих	-	Сар бүр			“Гурван тамга” ХХК-ийн удирдлагууд
<b>Нийт</b>		<b>500 000</b>				

## БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

*Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

№	БОМТ-ийн тайлагнахад талууд	биелэлтийг оролцогч	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал, төг	Хариуцан байгуулах тушаалтан	зохион албан
	Аймгийн болон сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд		Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр	9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	
			Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	11-р сард			
			Нөхөн сэргээлтийн аймаг, суманд хүлээлгэж өгөх	10-р сараас 11 сарын 1д багтааж			

## БҮЛЭГ 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

### Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд	1,800,000
2	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	500,000
3	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	1,500,000
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	4,000,000
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	300,000
6	Нөхөн сэргээлт, тэр бум мод зардал	6,500,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1,460,000
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	500,000
	<b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн</b>	<b>16 560 000</b>

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 16,560,000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 16,560,000 төгрөгийн 50 хувь буюу 8,280,000 төгрөг нөхөн сэргээлтийн дансанд байршуулна.